

ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬАТЫН ГАЗРЫН ӨМНӨД БҮС ДЭХ ГАЗРЫН
ТАВДУГААР САРД ХИЙЖ ГҮЙЦЭТГЭСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН
/2020.05.01-2020.05.31/

2020 оны 05 дугаар сарын 29

Даланзадгад хот

Гадаадын иргэн, харьяатын газрын Өмнөд бүс дэх газар нь холбогдох хууль тогтоомж, дүрэм, журмыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон 2020 оны 05 дугаар сарын 01-ний өдрөөс 2020 оны 05 дугаар сарын 31-ний өдрийн хооронд дараах ажлыг хийж гүйцэтгэлээ.

Нэг. Үндсэн үйл ажиллагааны хүрээнд

1.1. Виз, зөвшөөрлийн үйл ажиллагааны чиглэлээр:

Тайлант хугацаанд БНХАУ-ын 42 иргэний визийн сунгалтын материалыг бүрдүүлэн төвд хүргүүлж, тэмдэгтийн хураамж нийт 12.117.600 төгрөгийг холбогдох дансанд төвлөрүүлэн ажилласан.

Удирдлага, зохион байгуулалтын хүрээнд

Байгууллагын даргын 2020 оны 01,03,04 дүгээр албан даалгаврын хэрэгжилтийг ханган ажиллаж, биелэлтийг долоо хоногийн даваа гариг бүр холбогдох нэгжид хүргүүлэн ажиллаж байна.

Хүний нөөцийн програмд 22 албан хаагчийн цалин, хоолны хөнгөлөлт, төрийн захиргааны 10 албан хаагчийн төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл, зэрэг дэв, төрийн үйлчилгээний 2 албан хаагчийн төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл зэрэг мэдээллийг тухай бүр нь шивж ажилласан. Шинээр томилогдсон 2 албан хаагчийн мэдээллийг шивж, шилжин ажилласан 1 албан хаагчийг чөлөөлж ажилласан.

Тус газрын ахлах нягтлан бодогч шилжин ажиллах болсонтой холбогдуулан газрын даргын 2020 оны 05 дугаар сарын 08-ны өдрийн 01 дүгээр “Ажил хүлээлцэх удирдамж”-ийн дагуу шинээр томилогдсон болон шилжин ажиллаж буй албан хаагчдын ажлыг хүлээлцэн үр дүнг газрын даргад илтгэх хуудсаар танилцуулан ажилласан.

Улсын онцгой комиссын 9 дүгээр тогтоолоор Ковид-19 халдвараас урьдчилан сэргийлэх болзошгүй эрсдэлээс хамгаалах, иргэдийн оролцоог нэмэгдүүлэх хариуцлагыг дээшлүүлэх, халдвараас сэргийлэх эрүүл ахуйн зөв дадал, хэвшлийг төлөвшүүлэх зорилготой аяныг “Амны хаалт-бидний амьдралын баталгаа” уриан дор 2020 оны 05 дугаар сарын 18-ны өдөр зохион байгуулан ажиллалаа.

Аяны хүрээнд Даланзадгад сумын худалдааны төвүүд, ундны ус түгээх цэгүүд, гэр хорооллын гудамжаар явж амны хаалтгүй иргэд, бага насны хүүхдүүдэд амны хаалт зүүхийг уриалж, өөрсдийн нөөц бололцоогоор ковид 19 халдвараас урьдчилан сэргийлэх зөвлөмж бүхий 60 ширхэг зурагт хуудас, 85 ширхэг амны хаалтыг тарааж ажилласан болно.

1.1.Өргөдөл, гомдлын мэдээ

- Бүртгэсэн өргөдөл, гомдлын тоо /Хүлээн авсан/-1
- Шийдвэрлэсэн өргөдөл, гомдлын тоо-1

- Шилжүүлсэн өргөдөл, гомдлын тоо-0
- Шийдвэрлэлтийн шатанд байгаа болон хугацаа сунгасан өргөдөл, гомдлын тоо-0
- Баримт бичиг боловсруулалтын хүрээнд /Тушаал-1/
- Төв газарт явуулсан бичиг /илтгэх хуудас-5/
- Явуулсан бичиг /албан тоот-4/
- Бусад байгууллагаас ирсэн бичиг-8
- Боомт орон нутагт явуулсан дотоод албан бичиг-0

1.2. Санхүү, хангалт үйлчилгээний чиглэлээр:

Энэ оны 05 дугаар сард 37,709,500 төгрөгийн санхүүжилт авч нийт 22 албан хаагчийн цалинд 21,587,031.71 төгрөгийг олгож, нийгмийн даатгалын шимтгэлд 2,771,814.76 төгрөг, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал болох байрны түрээсийн зардалд 2,434,846 төгрөг, хангамж, бараа материалын зардалд 4,027,982 төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний зардалд 1,131,858 төгрөг, урсгал засварын зардалд 98,000 төгрөг, бараа үйлчилгээний бусад зардалд 500,000 төгрөгийн гүйлгээ хийж Өмнөговь аймгийн Төрийн сангаар баталгаажуулан гүйлгээ хийж ажилласан байна.

Тус газрын 2020 оны 04 дүгээр сарын шилэн дансны мэдээллийг цахим сайтад байршуулж тоон мэдээг дараа сарын 02-ны дотор холбогдох нэгжид хүргүүлж ажилласан.

1.3. Мэдээлэл технологийн чиглэлээр:

Газрын хэмжээнд сүлжээний хэвийн байдлыг ханган ажиллаж байна. Тайлант хугацаанд албан хаагчдаас сүлжээ тасалдсан, компьютерийн хэвийн бус ажиллагаатай холбоотой нийт 3 дуудлага ирүүлснийг тухай бүр засч сайжруулан ажилласан.

Хоёр. Бусад

2.1 Шинэ коронавирусын /ковид-19/ дэгдэлт ихэссэнтэй холбоотойгоор Монгол Улсын Засгийн газар, Улсын онцгой комисс, Өмнөговь аймгийн онцгой комисс болон байгууллагын даргын гаргасан шийдвэрүүдийг өдөр тутмын үйл ажиллагаанд мөрдөн ажиллаж байна. Тухайлбал, албан хаагчдын дархлааг дэмжих зорилгоор халуун чацаргана, витамин, гар ариутгах бодисоор ханган, албаны өрөөнүүдийн цэвэрлэгээ, ариутгал халдваргүйтлийг сайжруулан ажиллаж байна.

Мөн байгууллагын даргын гаргасан албан даалгаврын биелэлт, уг вирусээс урьдчилан сэргийлэх төлөвлөгөөний биелэлтийг нэгтгэн гаргаж холбогдох нэгжид хугацаанд нь хүргүүлэн ажиллаж байна.

ӨМНӨД БҮС ДЭХ ГАЗАР